

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Засаг Даргын Тамгын Газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/90/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Аудитын менежер: Б.Батмөнх	Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2024 он	Утас: 7036-3036 Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442	Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Т.Болор Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	14-19
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. Аудитын тайлан	20-23
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
5. Аудитын илрүүлэлт	24-27
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	28-30

Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗДҮАХХХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ө.СУВДАА ТАНАА

2024.02.23 № СЗА-2024/90-НА-СТА-ТЦЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Засаг Даргын Тамгын Газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Засаг Даргын Тамгын Газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,090,646.2 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр нийт 5,009,935.3 мянган төгрөг зарцуулж, 98.4 хувьтай тайлагнагдсан нь үндсэн үйл ажиллагааны зардал 26,880.7 мянган төгрөгөөр, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ 35,525.9 мянган төгрөгөөр хэмнэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймаг нь орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж, өөрийгөө бүрэн санхүүжүүлсэн, Засгийн газрын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхийн төлөө үр бүтээлтэй ажиллаж байгааг үнэлж, Засгийн

Газрын 2022 оны 419 дүгээр тогтоолоор 200,000.0 мянган төгрөгөөр шагнасныг 2023 онд аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн байна.

Уг эх үүсвэрээр Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрийн “Ерөнхий гэрээгээр худалдаж буй барааны жагсаалт”-д бүртгэгдсэн Ай Ти Зон ХХК-иас компьютер, тоног төхөөрөмжийг худалдан авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймгийн ЗДТГ нь тайлант онд “Иргэдийн оролцоотой цахим хөгжлийн жил-2023” зорилгыг дэвшүүлж, 7 зорилт, 179 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96.1 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	324,250,354.54	168,130,524.00
33	АВЛАГА	213,728,444.54	11,957,414.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	202,368,893.54	11,957,414.00
33500	Бусад авлага	11,359,551.00	-
33510	Байгууллагаас авах авлага	11,359,551.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	110,521,910.00	156,173,110.00
35100	Түүхий эд материал	2,801,000.00	2,801,000.00
35130	Эм боох материал	2,801,000.00	2,801,000.00
35400	Хангамжийн материал	107,720,910.00	153,372,110.00
35410	Бичиг хэргийн материал	14,343,300.00	24,895,250.00
35420	Аж ахуйн материал	51,371,460.00	65,124,910.00
35440	Түлш, шатах тослох материал	2,425,000.00	9,863,000.00
35450	Барилгын засварын материал	375,000.00	475,000.00
35460	Хүнсний материал	82,150.00	2,879,950.00
35470	Бусад хангамжийн материал	39,124,000.00	50,134,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,833,704,680.96	2,001,727,445.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,833,704,680.96	2,001,727,445.28
39200	Биет хөрөнгө	1,228,134,014.32	1,396,893,445.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,405,998,671.00	1,405,998,671.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(506,871,725.92)	(594,270,955.72)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	284,200,000.00	537,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(249,761,111.13)	(337,149,999.98)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	496,910,342.37	721,949,927.61
39206	Хуримтлагдсан элэгдэл	(316,191,226.98)	(456,627,387.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	337,044,379.00	392,127,549.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	(237,460,527.91)	(280,614,787.03)
39214	Бусад үндсэн хөрөнгө	70,294,100.00	70,294,100.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(56,028,886.11)	(62,513,672.38)
39300	Биет бус хөрөнгө	605,570,666.64	604,834,000.00
39301	Програм хангамж	2,613,000.00	10,593,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(776,333.36)	(9,493,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	603,734,000.00	603,734,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,157,955,035.50	2,169,857,969.28
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	202,368,893.54	11,957,414.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	202,368,893.54	11,957,414.00
41300	Өглөг	202,368,893.54	11,957,414.00
41360	Бусад өглөг	202,368,893.54	11,957,414.00
41361	Байгууллагад төлөх өглөг	202,368,893.54	11,957,414.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,955,586,141.96	2,157,900,555.28
51	Засгийн газрын хувь оролцоо	1,955,586,141.96	2,157,900,555.28
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,765,498,366.00	2,765,498,366.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,765,498,366.00	2,765,498,366.00
51200	Хуримтлагдсан үр дүн	(1,876,508,051.98)	(1,674,193,638.66)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,612,390,310.89)	(1,876,508,051.98)
51220	Тайлант үеийн үр дүн	(264,117,741.09)	202,314,413.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,066,595,827.94	1,066,595,827.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,157,955,035.50	2,169,857,969.28

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

				/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,431,053,176.10	8,425,867,299.29	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,817,278.00	296,604,595.63	
120	Нийтлэг татварын бус орлого	48,817,278.00	296,604,595.63	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,817,278.00	25,882,900.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,817,278.00	25,882,900.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	13,000,000.00	270,721,695.63	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,382,235,898.10	8,129,262,703.66	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,598,858,923.58	3,145,210,278.54	
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	280,100,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,500,000,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,598,858,923.58	1,287,370,123.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	77,740,155.54	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,783,376,974.52	4,984,052,425.12	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,783,376,974.52	4,984,052,425.12	
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,695,170,917.19	8,223,552,885.97	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,695,170,917.19	8,223,552,885.97	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,562,027,999.39	8,107,353,144.93	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,203,635,835.99	2,200,064,884.45	
210101	Үндсэн цалин	800,630,341.23	1,173,480,956.67	
210102	Нэмэгдэл	267,050,639.75	678,911,053.86	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	50,006,108.69	155,085,005.40	
210104	Урамшуулал	83,987,746.32	192,587,868.52	
210105	Гэрээт ажлын хөлс	1,961,000.00	-	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135,755,573.19	256,115,847.23	
210201	Тэтгэврийн даатгал	92,761,277.16	175,053,670.73	
210202	Тэтгэмжийн даатгал	10,870,237.91	20,715,187.40	
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,568,510.40	16,378,036.90	
210204	Ажилгүйдлийн даатгал	1,987,947.44	3,598,997.75	
210205	Эрүүл мэндийн даатгал	21,567,600.28	40,369,954.45	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	510,386,109.00	525,331,599.25	
210301	Гэрэл, цахилгаан	38,209,168.00	49,798,132.25	
210302	Түлш, халаалт	393,741,600.00	393,864,427.00	
210303	Цэвэр, бохир ус	25,860,516.00	28,883,330.00	
210304	Байрны түрээс	52,574,825.00	52,785,710.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	241,385,126.00	227,202,888.66	
210401	Бичиг хэрэг	79,202,229.00	42,314,510.00	
210402	Тээвэр, шатахуун	106,905,000.00	98,491,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,518,897.00	29,368,874.66	
210404	Ном, хэвлэл	5,238,800.00	-	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	350,000.00	260,000.00	

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,170,200.00	56,768,504.00
2105	Нормативт зардал	47,633,173.00	16,577,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,933,400.00	-
210502	Хоол, хүнс	40,499,773.00	11,092,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,200,000.00	5,484,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59,476,600.00	56,132,780.00
210604	Урсгал засвар	59,476,600.00	56,132,780.00
2107	Томилолт, зочны зардал	96,784,160.00	150,538,059.00
210702	Дотоод албан томилолт	62,784,700.00	137,073,800.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	33,999,460.00	13,464,259.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,567,740.00	58,664,107.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,355,074.00	50,041,309.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,384,000.00	938,070.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,516,800.00	2,626,810.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	220,000.00	308,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,600,000.00	1,622,000.00
210807	Газрын төлбөр	491,866.00	3,127,918.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,222,403,682.21	4,616,725,879.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,876,447,584.16	4,274,032,885.03
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,338,062.00	6,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	339,618,036.05	336,692,994.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	133,142,917.80	116,199,741.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	106,394,459.80	108,553,360.50
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	31,857,700.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,412,987.80	44,944,503.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	53,123,772.00	63,608,857.50
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	26,748,458.00	7,646,380.54
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	26,748,458.00	7,646,380.54
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(264,117,741.09)	202,314,413.32
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(264,117,741.09)	202,314,413.32

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,418,053,176.10	8,155,145,603.66	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,817,278.00	25,882,900.00	
120	Нийтлэг татварын бус орлого	35,817,278.00	25,882,900.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,817,278.00	25,882,900.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,817,278.00	25,882,900.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,382,235,898.10	8,129,262,703.66	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,598,858,923.58	3,145,210,278.54	
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	280,100,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,500,000,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,598,858,923.58	1,287,370,123.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	77,740,155.54	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,783,376,974.52	4,984,052,425.12	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,783,376,974.52	4,984,052,425.12	
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,346,461,276.10	7,921,151,540.66	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,346,461,276.10	7,921,151,540.66	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,010,949,464.76	7,793,294,385.62	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,203,635,835.99	2,187,283,180.71	
210101	Үндсэн цалин	800,630,341.23	1,173,480,956.67	
210102	Нэмэгдэл	267,050,639.75	678,911,053.86	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	50,006,108.69	141,143,301.66	
210104	Урамшуулал	83,987,746.32	193,747,868.52	
210105	Гэрээт ажлын хөлс	1,961,000.00	-	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135,755,573.19	256,328,303.00	
210201	Тэтгэврийн даатгал	92,761,277.16	175,053,670.73	
210202	Тэтгэмжийн даатгал	10,870,237.91	20,715,187.40	
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,568,510.40	16,378,036.90	
210204	Ажилгүйдлийн даатгал	1,987,947.44	3,811,453.52	
210205	Эрүүл мэндийн даатгал	21,567,600.28	40,369,954.45	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	510,386,109.00	525,331,599.25	
210301	Гэрэл, цахилгаан	38,209,168.00	49,798,132.25	
210302	Түлш, халаалт	393,741,600.00	393,864,427.00	
210303	Цэвэр, бохир ус	25,860,516.00	28,883,330.00	
210304	Байрны түрээс	52,574,825.00	52,785,710.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	132,300,527.00	211,941,969.66	
210401	Бичиг хэрэг	16,739,030.00	39,196,934.00	
210402	Тээвэр, шатахуун	64,183,600.00	97,331,274.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,518,897.00	31,699,544.66	
210404	Ном, хэвлэл	1,338,800.00	-	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	350,000.00	260,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,170,200.00	43,454,217.00	

2105	Нормативт зардал	13,003,000.00	16,577,100.00
210502	Хоол, хүнс	11,803,000.00	11,092,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,200,000.00	5,484,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	117,457,000.00	67,612,230.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	39,291,000.00	-
210602	Тавилга	19,608,400.00	10,112,950.00
210604	Урсгал засвар	58,557,600.00	57,499,280.00
2107	Томилолт, зочны зардал	118,378,160.00	150,538,059.00
210702	Дотоод албан томилолт	84,378,700.00	137,073,800.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	33,999,460.00	13,464,259.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,567,740.00	58,664,107.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,355,074.00	50,041,309.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,384,000.00	938,070.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,516,800.00	2,626,810.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	220,000.00	308,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,600,000.00	1,622,000.00
210807	Газрын төлбөр	491,866.00	3,127,918.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,735,465,519.58	4,319,017,837.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,729,127,457.58	4,313,017,837.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,338,062.00	6,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	335,511,811.34	127,857,155.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	106,394,459.80	108,353,360.50
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	31,857,700.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,412,987.80	44,944,503.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	53,123,772.00	63,408,857.50
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	229,117,351.54	19,503,794.54
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	229,117,351.54	19,503,794.54
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	71,591,900.00	233,994,063.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	71,591,900.00	233,994,063.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	71,591,900.00	233,994,063.00
2200	Дотоод эх үүсвэрээр	71,591,900.00	233,994,063.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	71,591,900.00	233,994,063.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(71,591,900.00)	(233,994,063.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,765,498,366.00	1,066,595,827.94	(1,612,390,310.89)	2,219,703,883.05
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,765,498,366.00	1,066,595,827.94	(1,612,390,310.89)	2,219,703,883.05
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(264,117,741.09)	(264,117,741.09)
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,765,498,366.00	1,066,595,827.94	(1,876,508,051.98)	1,955,586,141.96
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,765,498,366.00	1,066,595,827.94	(1,876,508,051.98)	1,955,586,141.96
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,765,498,366.00	1,066,595,827.94	(1,876,508,051.98)	1,955,586,141.96
19	Тайлант үеийн үр дүн	-	-	202,314,413.32	202,314,413.32
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,765,498,366.00	1,066,595,827.94	(1,674,193,638.66)	2,157,900,555.28

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,090,646,200.00	5,009,935,325.12	80,710,874.88	98.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,090,646,200.00	5,009,935,325.12	80,710,874.88	98.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,982,989,100.00	4,902,291,964.62	80,697,135.38	98.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,210,266,900.00	2,186,123,180.71	24,143,719.29	98.91
210101	Үндсэн цалин	1,189,957,900.00	1,173,480,956.67	16,476,943.33	98.62
210102	Нэмэгдэл	687,033,000.00	678,911,053.86	8,121,946.14	98.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	198,800,000.00	141,143,301.66	57,656,698.34	71.00
210104	Урамшуулал	134,476,000.00	192,587,868.52	(58,111,868.52)	143.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	289,293,500.00	256,328,303.00	32,965,197.00	88.60
210201	Тэтгэврийн даатгал	196,719,600.00	175,053,670.73	21,665,929.27	88.99
210202	Тэтгэмжийн даатгал	23,143,500.00	20,715,187.40	2,428,312.60	89.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,514,700.00	16,378,036.90	2,136,663.10	88.46
210204	Ажилгүйдлийн даатгал	4,628,700.00	3,811,453.52	817,246.48	82.34
210205	Эрүүл мэндийн даатгал	46,287,000.00	40,369,954.45	5,917,045.55	87.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	533,713,700.00	525,331,599.25	8,382,100.75	98.43
210301	Гэрэл, цахилгаан	55,797,000.00	49,798,132.25	5,998,867.75	89.25
210302	Түлш, халаалт	393,741,400.00	393,864,427.00	(123,027.00)	100.03
210303	Цэвэр, бохир ус	27,600,000.00	28,883,330.00	(1,283,330.00)	104.65
210304	Байрны түрээс	56,575,300.00	52,785,710.00	3,789,590.00	93.30
2104	Хангамж, бараа материалын зардал	207,241,800.00	207,240,919.66	880.34	100.00
210401	Бичиг хэрэг	39,150,000.00	38,972,234.00	177,766.00	99.55
210402	Тээвэр, шатахуун	97,320,000.00	97,231,274.00	88,726.00	99.91
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	29,160,000.00	31,423,544.66	(2,263,544.66)	107.76
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	412,000.00	260,000.00	152,000.00	63.11
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	41,199,800.00	39,353,867.00	1,845,933.00	95.52
2105	Нормативт зардал	5,500,000.00	5,484,150.00	15,850.00	99.71
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,500,000.00	5,484,150.00	15,850.00	99.71
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	101,500,000.00	99,576,380.00	1,923,620.00	98.10
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,000,000.00	20,077,100.00	1,922,900.00	91.26
210602	Тавилга	22,000,000.00	22,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	57,500,000.00	57,499,280.00	720.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	144,551,400.00	143,818,559.00	732,841.00	99.49
210702	Дотоод албан томилолт	130,551,400.00	130,354,300.00	197,100.00	99.85
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	14,000,000.00	13,464,259.00	535,741.00	96.17
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,648,000.00	57,414,107.00	12,233,893.00	82.43
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	58,400,000.00	48,791,309.00	9,608,691.00	83.55

	үйлчилгээний төлбөр хураамж				
210803	Даатгалын үйлчилгээ	1,384,000.00	938,070.00	445,930.00	67.78
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,070,000.00	2,626,810.00	443,190.00	85.56
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	394,000.00	308,000.00	86,000.00	78.17
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,400,000.00	1,622,000.00	778,000.00	67.58
210807	Газрын төлбөр	4,000,000.00	3,127,918.00	872,082.00	78.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,421,273,800.00	1,420,974,766.00	299,034.00	99.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,415,273,800.00	1,414,974,766.00	299,034.00	99.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,000,000.00	6,000,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	107,657,100.00	107,643,360.50	13,739.50	99.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	107,657,100.00	107,643,360.50	13,739.50	99.99
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	44,952,100.00	44,944,503.00	7,597.00	99.98
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	62,705,000.00	62,698,857.50	6,142.50	99.99
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,090,646,200.00	5,009,935,325.12	80,710,874.88	98.41
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,045,646,200.00	4,984,052,425.12	61,593,774.88	98.78
320001	Орон нутгийн төсвөөс	5,045,646,200.00	4,984,052,425.12	61,593,774.88	98.78
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	45,000,000.00	25,882,900.00	19,117,100.00	57.52
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,000,000.00	25,882,900.00	19,117,100.00	57.52
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	217.00	217.00	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	108.00	108.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	9.00	9.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	46.00	46.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	53.00	53.00	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	108.00	108.00	-	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	49.00	49.00	-	100.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	4.00	4.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	53.00	53.00	-	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	2.00	2.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,145,210,278.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,145,210,278.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,124,996,484.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,160,000.00
210104	Урамшуулал		1,160,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		4,701,050.00
210401	Бичиг хэрэг		224,700.00
210402	Тээвэр, шатахуун		100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		276,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		4,100,350.00
2105	Нормативт зардал		11,092,950.00
210502	Хоол, хүнс		11,092,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		202,029,913.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		202,029,913.00
2107	Томилолт, зочны зардал		6,719,500.00
210702	Дотоод албан томилолт		6,719,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,250,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,898,043,071.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		2,898,043,071.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		20,213,794.54
2132	Бусад урсгал шилжүүлэг		710,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		710,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		19,503,794.54
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		19,503,794.54
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		3,145,210,278.54
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		3,145,210,278.54
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		280,100,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,500,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,287,370,123.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		77,740,155.54

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газар *Ицаашид ЗДТГ гэх* нь 2023 онд “Иргэдийн оролцоотой цахим хөгжлийн жил-2023” гэсэн зорилгыг тавьж ажиллажээ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасныг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах;
- Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах;
- Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах;
- Хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох;
- Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;
- Төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;
- Тухайн шатны Хурлын хэвийн үйл ажиллагааг ханган үйлчлэх гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул байна гэж үзлээ.

ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт тавьж, ажилладаг бөгөөд тайлант онд санхүүгийн хяналт, дотоод аудит хийгдээгүй хэдий ч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг гүйцэтгэсэн байна.

Дотоод хяналт, шалгалтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад харьяалагдах төсөвт байгууллагуудын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,902.9 мянган төгрөгөөр буюу 0.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	213,728.4	11,957.4	(201,771.0)
Бараа материал	110,521.9	156,173.1	45,651.2
Үндсэн хөрөнгө	1,833,704.7	2,001,727.4	168,022.7
Нийт хөрөнгө	2,157,955.0	2,169,857.9	11,902.9
Өр төлбөр	202,368.9	11,957.4	(190,411.5)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,955,586.1	2,157,900.5	202,314.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,157,955.0	2,169,857.9	11,902.9

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.
Үүнд:

- Авлагын данс 11,957.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдаж, 201,771.0 мянган төгрөгөөр буурсан нь нэмэлт санхүүжилтийн дансны татаас санхүүжилтийн авлага 202,368.9 мянган төгрөгийг хүлээн авсан болон Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ-ын гэрээний дагуу төвлөрүүлсэн орлого 11,957.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар тусгаснаас,
- Бараа материалын дансны үлдэгдэл 156,173.1 мянган төгрөг болж, 45,651.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 280,639.6 мянган төгрөгийн материал худалдан авч, 234,988.4 мянган төгрөгийн материалыг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,001,727.4 мянган төгрөг болж, 168,022.7 мянган төгрөгөөр өссөн нь батлагдсан төсвөөс болон төсвийн урамшууллын орлогоор 233,994.1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, Засгийн Газрын 2023 оны 208 дугаар тогтоолоор Улсын нөөцөөс 253,500.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл шилжүүлэн авсан болон тайлант хугацаанд 373,580.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал нэмж байгуулснаас голлон шалтгаалсан байна.
- Өр төлбөрийн дансны үлдэгдэл 11,957.4 мянган төгрөг болж, 190,411.5 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 202,368.9 мянган төгрөг, тайлант онд төвлөрүүлсэн 11,957.4 мянган төгрөгийг тус тус бүртгэснээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

ЗДТГ-ын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 4,314,463.4 мянган төгрөг, өөрийн орлогоос 45,000.0 мянган төгрөг, нийт 4,359,463.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 912,694.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хангамж, бараа материалын зардлыг 44,545.1 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 190,019.8 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 106,992.0 мянган төгрөгөөр, мэдээлэл, сурталчилгааны зардлыг 64,861.4 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэгийг 36,394.6 мянган төгрөгөөр, орон нутгийн нөөц хөрөнгийг 394,726.2 мянган төгрөгөөр бууруулсан зэргээр нийт дүнгээр 26,901.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 4,386,365.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны төсвийн тодотгол, зохицуулалтаар цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 160,788.9 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 81,860.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 34,000.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, төлбөр хураамжийг 54,500.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 324,000.0 мянган төгрөгөөр зэрэг нийт дүнгээр 704,281.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 5,090,646.2 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,090,646.2 мянган төгрөгийн төсөв баталж, орон нутгийн төсвөөс 5,045,646.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 45,000.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 4,984,052.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 25,882.9 мянган төгрөг, нийт 5,009,935.3 мянган төгрөгийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,009,935.3 мянган төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардал 26,880.7 мянган төгрөгөөр, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ 35,525.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
А	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	5,090,646.2	5,009,935.3	80,710.9	98.4
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,889,544.3	1,862,663.6	26,880.7	98.6
2	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	1,035,957.3	1,000,431.4	35,525.9	96.6
3	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	591,213.7	582,830.9	8,382.8	98.6

4	Мэдээлэл сурталчилгааны зардал	1,000.0	880.0	120.0	88.0
5	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс /ТАСЗ/	50,000.0	40,511.3	9,488.7	81.0
6	Биеийн тамирын уралдаан, тэмцээн	5,000.0	4,998.9	1.1	100.0
7	Уналга, цугларалт бэлтгэл сургууль	40,000.0	39,981.8	18.2	100.0
8	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	107,657.1	107,643.4	13.7	100.0
9	Орон нутгийн нөөц хөрөнгө	1,355,273.8	1,355,070.4	203.4	100.0
10	Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх	15,000.0	14,923.7	76.4	99.5
	Дүн	5,090,646.2	5,009,935.3	80,710.9	98.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн 100130051415 тоот дансанд нийт 3,145,210.3 мянган төгрөгийн дараах орлогыг төвлөрүүлж, 3,125,706.5 мянган төгрөгийг 5 хөтөлбөрийн 10 арга хэмжээнд зориулалтын дагуу зарцуулж, 19,503.8 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Засгийн газрын нөөц сангаас 1,500,000.0 мянган төгрөг,
- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн газраас аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө хийлгэх ажлын санхүүжилтэд 280,000.0 мянган төгрөг,
- Жендерийн үндэсний хорооноос 100.0 мянган төгрөг,
- Архивын гэрээт ажилчдын цалинд 15,035.5 мянган төгрөг,
- Төрийн албаны зөвлөлөөс шалгалт зохион байгуулах зардалд 8,274.0 мянган төгрөг,
- Удирдлагын академийн сургалтад 17,319.5 мянган төгрөг,
- Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ-ын гэрээний орлого 16,104.0 мянган төгрөг,
- ОНХС-аас улсын баяр наадмын зардалд 200,000.0 мянган төгрөг,
- Татаас санхүүжилтийн авлагын 202,368.9 мянган төгрөг,
- ЗДҮАХХ-ийн зардлын санхүүжилт 906,008.4 мянган төгрөг.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан 22,000.0 мянган төгрөгийн багаж, техник хэрэгсэл *Итавилга худалдаж авсан*, 67,610.0 мянган төгрөгийн шатахууны худалдан авах ажиллагааг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулаагүй байна.

Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоолоор шагнасан шагналын хөрөнгө буюу төсвийн урамшуулал, аймгийн ЗДҮАХХ -ийн багаж, техник, хэрэгслийн төсвийн эх үүсвэрээр Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрийн "Ерөнхий гэрээгээр худалдаж буй барааны жагсаалт"-д бүртгэгдсэн Ай Ти Зон ХХК-ийн компьютер, тоног төхөөрөмжийг нийт худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсвийн төлөвлөлт, анхан шатны баримттай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02/54 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,695,170.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 56,951.7 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант оны төсөв, санхүүжилт материаллаг хэмжээгээр өөрчлөгдсөн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 8,263,253.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон 82,632.5 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, баталсан төсвийн хүрээнд ил тод байдлыг ханган ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд ЗДТГ-ын мэдээлбэл зохих 28 төрлийн 168 мэдээллээс 12 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 10 мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.5 дахь “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор” 6.4 дэх “дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.5: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан 20,369.9 мянган төгрөгийн багаж техник хэрэгсэл, 67,610.0 мянган төгрөгийн шатахууны худалдан авах ажиллагааг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулаагүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална”, 48 дугаар зүйлийн 48.5-т “Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн

2. “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнах, хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсны үндсэн дээр худалдан авалтыг хийж гүйцэтгэх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл, худалдан авах ажиллагаа нь Шилэн дансны тухай хууль, ТБОНӨХБАУХА тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 26,454.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 6 албан шаардлага, 9,165.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөгдсөнөөс албан хаагчдын албан томилолтоор ажилласан хугацаанд унаа, хоолны хөнгөлөлт тооцож олгосон зөрчлийг тайлант онд давтан гаргасан байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	6	26,454.8	5	26,016.8	83.3
Зөвлөмж	3	9,165.0	3	9,165.0	100.0
Нийт дүн	9	35,619.8	8	35,181.8	88.9

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн **191,171.8** мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгө худалдан авсан зардлыг 191,171.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.

Аудитаар нийт **173,592.9** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **3,968.0** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **75,780.5** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, **93,844.4** мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос **3,968.0** мянган төгрөгийг илүү олгосон дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Албан хаагчдыг албан томилолтоор Улаанбаатар хот, аймаг, сумдад ажилласан хугацаанд хоолны хөнгөлөлт **968.0** мянган төгрөгийг давхардуулан тооцож, олгосон,
- Аймгийн ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс Засаг даргын 2023 оны А/316 дугаар захирамжаар А.Эрхэмд олгох **3,000.0** мянган төгрөгийн буцалтгүй тусламжийг /гүйлгээг аав, ээжийнх нь харилцах дансанд давхардуулан хийсэн/ илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Засаг даргын 2023 оны А/316 дугаар захирамж-д “Сүхбаатар сумын иргэн А.Эрхэм нь ... буцалтгүй тусламжид шаардагдах 3,000.0 мянган төгрөгийг ЗДНХ-өөс гаргах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон хоолны хөнгөлөлт, буцалтгүй тусламжийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс дараах **75,780.5** мянган төгрөгийн зориулалт бус зардлуудыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

1. Засаг дарга, Засаг даргын орлогч болон ЗДТГ-ын албан хаагчдын гадаад, дотоод албан томилолтод 36,130.8 мянган төгрөг зарцуулсан байна. Үүнд:
 - Гадаад томилолтод 29,231.0 мянган төгрөг,
 - Дотоод буюу цэрэг татлагын томилолтод 6,899.8 мянган төгрөг.
2. Дараах байгууллагуудад компьютер, тоног төхөөрөмж худалдан авахад 39,649.7 мянган төгрөг зарцуулсан байна. Үүнд:

- *Шаамар сумын ЭМТ-д 1,599.9 мянган төгрөгийн хөргүүр,*
- *Орхонтуул сум, Тарни баг, Хэрх тосгоны Соёлын төвд 24,000.0 мянган төгрөгийн хөгжим, тоног төхөөрөмж,*
- *Аймгийн Цагдаагийн газарт 8,199.8 мянган төгрөгийн телевизор, компьютер,*
- *Оюун ухааны академийн Сэлэнгэ салбарт 2,850.0 мянган төгрөгийн компьютер,*
- *Ус, цаг уур орчны шинжилгээний газарт 3,000.0 мянган төгрөгийн компьютер зэрэг.*

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь “ Урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс томилолтын болон хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Хэдийгээр байгууллагын дүнгээр нийт батлагдсан төсвийн төлөвлөгөөг хэтрүүлээгүй боловч зайлшгүй гарах зардлыг холбогдох зардал, эдийн засгийн ангилал, арга хэмжээн дээр тусгаагүй буюу төсвийг иж бүрэн, үнэн зөв төлөвлөөгүй, шаардлагатай тохиолдолд төсөвт зохицуулалт хийлгэх саналыг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж, шийдвэрлүүлээгүйгээс төсвийг зардлын бүлэг, эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан байна. Үүнд:

- *Байгууллагын үндсэн үйл ажиллагааны буюу тээврийн хэрэгслийн сэлбэг, дугуй, тос тосолгоо, засвар үйлчилгээний зардлын төсвийг төлөвлөж, батлуулаагүйгээс барилгын тогтмол зардлын арга хэмжээний урсгал засварын зардлын батлагдсан төсвөөс **41,075.0** мянган төгрөгийг зарцуулсан,*
- *Жил бүр давтагддаг, урьдчилан төлөвлөх боломжтой цэрэг татлага, уналгын болон ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөний зардлыг холбогдох төсөвт тусгаж, төлөвлөөгүйгээс ЗДНХ-ийн төсвөөс **49,745.4** мянган төгрөгийн дараах зардлуудыг санхүүжүүлсэн байна. Үүнд:*
- *Цэрэг татлага, уналгын зардалд 26,073.1 мянган төгрөг,*
- *Жил бүр зохиогддог төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөнд 23,672.3 мянган төгрөг.*

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.2: Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 42 дугаар зүйлийн 42.2 дахь “Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно: 42.2.1:Төсвийн ерөнхийлөн захирагч нь: 42.2.1.а: Өөрийн төсвийн багцад хамаарах хөтөлбөр хооронд”, 42.3.1 дэх “Төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаггүй бол төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Жил бүр давтагдан, зайлшгүй гарах зардлуудыг холбогдох төсвийн ангилал, зардлын бүлгээр төлөвлөж, төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг ханган ажиллах.

2. Анхан шатны баримттай холбоотой асуудал:

2.1 Илрүүлэлт: Тус байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй хуучин тээврийн хэрэгслүүдийн насжилт, элэгдэл зэргийг тооцон, 100 км гүйлтэд зарцуулах шатахуунд хэмжилт, туршилт явуулж, бодит нормыг тогтоолгүйгээр жишиг нормоос хэтрүүлэн шатахуун зарцуулж, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр “Жишиг норм батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”, 3 дугаар хавсралтаар баталсан “Автомашин шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж”-ийн холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Тээврийн хэрэгслийн шатахуун зарцуулалтад хэмжилт, туршилт хийсний үндсэн дээр нормыг тогтоож, байгууллагын даргын тушаалаар баталгаажуулж мөрдөх.

2.2 Илрүүлэлт: ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс хэрэгжүүлсэн арга хэмжээний зарцуулалтын тайланг төсөвтэй нь зэрэгцүүлэн хянаж, хугацаанд нь хүлээн авч зориулалтын дагуу зарцуулсан эсэх, хэмнэлт гарсан эсэхийг тооцож, тодорхойлоогүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Нөөц хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг уг арга хэмжээг хэрэгжүүлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор гаргаж, тухайн шатны Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: ЗДНХ-ийн зарцуулалтын тайланг тогтоосон хугацаанд нь хянаж, хүлээн авах.

2.3 Илрүүлэлт: Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчаас түүний ашиглаж байсан 3,024.0 мянган төгрөгийн анхны өртөг бүхий IPAD нүүр танигчийг хүлээн аваагүй нь эд хөрөнгийн тооллогоор тогтоогдсон боловч тооллогын үр дүнг шийдвэрлэх арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, ... ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчаас уг хөрөнгийг хүлээн авч, тооцоог дуусгах арга хэмжээ авах.

2.4 Илрүүлэлт: ЗДТГ-ын эзэмшлийн албан байранд үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудтай байгуулсан гэрээнд сарын төлбөр, ашиглалтын зардлын хэмжээ, ашиглах хугацаа, тэдгээрээс төвлөрүүлэх орлого зэргийг тодорхой тусгаагүй, орлогын төвлөрүүлэлтэд хяналт тавиагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагуудтай байгуулсан гэрээнд сарын төлбөр, ашиглалтын зардлын хэмжээ, ашиглах хугацаа, тэдгээрээс төвлөрүүлэх орлого зэргийг тодорхой тусгаж, орлогын төвлөрүүлэлтэд хяналт тавих.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгө худалдан авсан зардлыг дутуу илэрхийлсэн.	1	191,171.8			1	191,171.8							
Дүн	1	191,171.8			1	191,171.8							

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос, хоолны хөнгөлөлт, буцалтгүй тусламжийг илүү олгосон.	1	3,968.0	1	3,968.0								
ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс зориулалт бус зардлуудыг санхүүжүүлсэн байна.	1	75,780.5			1	75,780.5						
Төсвийг иж бүрэн, үнэн зөв төлөвлөөгүй, шаардлагатай тохиолдолд төсөвт зохицуулалт хийлгэх саналыг төсвийн ерөнхийлөн захиралчид хүргүүлж, шийдвэрлүүлээгүй.	1	90,820.4					1	90,820.4				
Тээврийн хэрэгслүүдийн насжилт, элэгдэл зэргийг тооцон, бодит нормыг	1	-					1	-				

/мянган төгрөгөөр/

Үүнээс

тогтоолгүйгээр жишиг нормоос хэтрүүлэн шатахуун зарцуулж, бүртгэл тайланд тусгасан.																					
ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс хэрэгжүүлсэн арга хэмжээний зарцуулалтын тайланг төсөвтэй нь зэрэгцүүлэн хянаж, хугацаанд нь хүлээн аваагүй.	1	-												1	-						
Өндөр насны тэтгэвэрт гарсан албан хаагчаас IPAD хүлээн аваагүй.	1	3,024.0												1	3,024.0						
Ашиглагч байгууллагуудын гэрээнд сарын төлбөр, ашиглалтын зардлын хэмжээг тодорхой тусгаагүй, орлогын төвлөрүүлэлтэд хяналт тавиагүй.	1	-												1	-						
Дүн	7	173,592.9	1	3,968.0	1	75,780.5	5	93,844.4													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Үүнээс				/мянган төгрөгөөр/
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Төлбөрийн акт		Албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
12 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 10 мөнгөн гүйлгээг мэдээлээгүй.	1	-					1	-	
Дүн	1	-					1	-	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй, худалдан авах ажиллагааг цахимаар, нийгэд нээлттэй, ил тод зарлаагүй.	1	-					1	87,979.9	
Дүн	1	-					1	87,979.9	
Нийт дүн	2	-					2	87,979.9	